



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

Мухамед ишра СУМЫН
СОНГУУЛИЙН ХОРОО-Д

2024. 08. 08 № 452
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, ТЕЗ-ийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Ардын намын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Мөрийн хөтөлбөр (..... хуудас)-ийг хавсаргав.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

Түвшинширээ сумын МАН-ын хорооны
тэргүүлэгчдийн 2024 оны 06 дугаар
сарын 24-ны өдрийн хуралдааны *ас* тоот
тогтоолын хавсрлат

**СҮХБААТАР АЙМГИЙН ТҮВШИНШИРЭЭ СУМЫН 2024 ОНЫ ОРОН НУТГИЙН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МАН-ЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ
ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

- 1.1 Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлж буй орон сууцжуулах хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлэх бүх талын бодлогын дэмжлэгийг үзүүлнэ.
- 1.2 Гадаад дотоодод бэлтгэн сургах 3000 эмч, 10000 мянган сувилагч, 500 мэргэшсэн асрахуйн ажилтан бэлтгэх хөтөлбөрт сумын эмч, сувилагч, залуучуудыг хамруулах.
- 1.3 “Элэг бүтэн монгол”, Хүүхдийн “Эрүүл шүд”, “Умайн хүзүүн хавдаргүй монгол” хөтөлбөрт үзлэгүүдэд сумын иргэдийг хамруулах.
- 1.4 Сумын Эрүүл мэндийн төвийг дутагдалтай нарийн мэргэжлийн эмчээр хангах.
- 1.5 Сумын 0-5 насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэнэ.
- 1.6 Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.
- 1.7 Сумын төвийн орчныг бүрэн камержуулж, иргэдийн аюулгүй тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.
- 1.8 Хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хамгааллын үйлчилгээг сайжруулна
- 1.9 Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эхлүүлж байгаа иргэдэд дэмжлэг үзүүлж, нөхцлийг бүрдүүлж ажиллана.
- 1.10 Ахмадын өргөөг нэгдсэн халаалтын системд холбож, их засвар хийж, зориулалтын дагуу ашиглуулан, ахмад настнуудын хөдөлмөр

- эрхлэлтийг дэмжин, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагыг залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.11 Зудад өртсөн малчдыг малжуулах ажлыг төрөөс авч хэрэгжүүлж байгаа ажиллагаатай уялдуулан зохион байгуулж бүрэн хамруулах.
- 1.12 Зудын эрсдлийг даван туулахад баг бүр дээр техник хэрэгслээр хангаж, баг бүр дээр өвсний фондтой болох.
- 1.13 Зорилтот бүлгийн иргэдийг “Халамжаас хөдөлмөрт” хамруулан ажилд зуучлан, зөвлөн тусалж, ур чадвар эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна.
- 1.14 ЗДТГ-ын байрыг шинээр бариулахад орон нутгаас бодлогоор дэмжиж, төрийн үйлчилгээг тогтвортой явуулах боломжийг бүрдүүлж ажиллана.
- 1.15 Сумын соёлын өвийн баялаг байдлыг олон талт агуулгаар баяжуулж хамгаалан, улс орон, аймаг нутагт сурталчлан таниулах олон талт ажлыг зохион байгуулж, сумын музейг өргөжүүлэх
- 1.16 Сумын төвийн зам талбайг сайжруулан ногоон байгууламжийг нэмэгдүүлэх.
- 1.17 Идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэгсдийн идэвх санаачлагыг өрхүүлэн олон талт ажлыг зохион байгуулж, дэмжиж ажиллах.
- 1.18 Залуучуудын чөлөөт цагийн зөв боловсон өнгөрүүлэхэд анхаарч спорт заалтай болох
- 1.19 Хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд анхаарч хүүхдийн тоглоомын талбайтай болох.
- 1.20 Иргэдийн ундны усны хангамжийг сайжруулах зорилгоор усан санг нэмэгдүүлэх.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

- 2.1 Эдийн засгийн сэргэлт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.
- 2.2 Цэцэрлэг сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлж малчдын орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.3 Хүлэмжийн тариалалт хийх иргэдийг дэмжиж нарийн ногоогоор сумын иргэдийг хангах ажлыг зохион байгуулна.

2.4 Суурьшлын бүсийн эрчим хүчний шугамын өргөтгөл хийж, дэд станцын тоог нэмэгдүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлэх

2.5 Сумын түүх дурсгал бүхий газруудаар аялал жуулчлалын маршрут гаргаж, эко аялал жуулчлалын бааз бий болгох

2.6 Адуучин тэмцээнийг жил бүр зохион байгуулж, нутгийн адууны удам угшлыг сурталчлах

2.7 Шинэ хоршоо хөдөлгөөнийг сурталчлан, суманд үйл ажиллагаа явуулж байгаа болон шинээр байгуулагдаж байгаа хоршооны үйл ажиллагааг дэмжиж ажиллана,

2.8 Малчдыг хоршоолох замаар мах, сүү, арьс шир, худалдан борлуулах цех байгуулж ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.9 Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйн салбар болгон хөгжүүлнэ.

2.10 Малчдын залгамж халааг бэлтгэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ.

2.11 Малын үүлдэр угсаа, чанарыг сайжруулах ажлыг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

2.12 Малын тэжээлийн ургамлыг тариалах ажлыг нэмэгдүүлж, өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэх ажлыг иргэн, хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулна.

2.13 Малын тоо толгойн албан татварын зарцуулалтыг ард иргэдэд ил тод болгоно.


2.14 Туслах аж ахуй эрхлэх иргэд, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.

ГУРАВ: ХӨГЖЛИЙГ ХӨТЛӨХ ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ РЕФОРМ

3.1 Хүү багатай зээлд сумын иргэдийг хамруулж жижиг дунд бичил бизнесийг дэмжин ажлын байрыг нэмэгдүүлнэ.

3.2. Жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг иргэдийн бүтээгдэхүүний борлуулатыг төрийн худалдан авалтаар дэмжинэ.

ДӨРӨВ: ШУДАРГА ИРГЭДИЙН ОРОЛЦООНД
ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛ



- 4.1. Цахим орчин дахь ялгаварлан гадуурхал хүчирхийлэлгүй сум болох ажлыг өрнүүлж ажиллана.
- 4.2. Багийн хурлыг улирал бүр зохион байгуулж, сумын төвийн иргэдэд мэдээлэл хүргэж санал хүсэлтийг сонсох ажлыг сар бүр зохион байгуулна.
- 4.3. Багш, эмч, төрийн албан хаагчдын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.
- 4.4. Төрийн албан хаагч нь улс төрөөс ангид дарамтгүй ажиллах боломжийг бүрдүүлнэ.

ТАВ: ШИНЖЛЭХ УХААН, ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ,
ХИЙМЭЛ ОЮУН УХААН, ИХ ӨГӨГДӨЛД СУУРИЛСАН
ТӨРИЙН ХҮРТЭЭМЖИЙН ДАХИН ИНЖНЕРЧЛЭЛ

- 5.1. Төрийн албан хаагч нь ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй, намын харъяалалаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг хэрэгжүүлнэ.

ЗУРГАА: ХҮН БА ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧИН

- 6.1. Бэлчээрт хөнөөл учруулж байгаа царцаа, үлийн цагаан оготно гэх мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэнэ.
- 6.2 Хүн малын ундны усны эхийг хамгаалж, хүнсний зориулалтаар ашиглаж байгаа усыг шинжилгээнд оруулж байх.
- 6.3. Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж, айл өрх, байгууллага бүр мод тариалах ажлыг зохион байгуулна.
- 6.4. Эрчим хүчний хэмнэлттэй дэвшилтэт технологи бүхий амины болон нийтийн орон сууц барих иргэдийн санаачлагыг дэмжинэ.
- 6.5. Хог хаягдлыг дахин боловсруулах, байгальд сөрөг нөлөөлөхгүй аргаар устгах жижиг дунд үйлдвэрлэлийн төслийг нэвтрүүлж дэмжинэ.


ДОЛОО: ХОТ ХӨДӨӨГИЙН ТЭНЦВЭРИЙГ ХАНГАХ
БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 7.1. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 7.2. Айл өрх албан байгууллага аж ахуйн нэгжийг нэгдсэн халаалтын системд холбох.

7.3. Ёслол хүндэтгэлийн өргөө байгуулна.

7.4. Сумын төвд сайжруулсан шороон зам тавьж тэмдэгжүүлэлт, гэрэлтүүлэг хийх.

НАЙМ: ҮНДЭСНИЙ СӨРӨН ТЭСВЭРЛЭХ
ЧАДАЛ БА ОЛОН УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ



8.1. Сумын байгууллага, ард иргэдийг гамшигийн эрсдэлтэй нөхцөлд ажиллах арга ажиллагаанд сурган дадлагажуулах.

8.2. Байгаль цаг агаарын аюултай үзэгдлийн мэдээллийг иргэдэд хүргэх ажлыг шуурхай болгон урьдчилан сэргийлж ажиллана.

СҮХБААТАР АЙМГИЙН ТҮВШИНШИРЭЭ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО